



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар A/04

Рашаант сум

Журам шинэчлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны "Журам шинэчлэн батлах тухай" 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сумын аварга малчин" өрх, Сумын аварга саальчин"-аар шалгаруулах журмыг 1, 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Сумын аварга малчин өрх", "Сумын аварга саальчин"-ыг шалгаруулахад шаардагдах хөрөнгийг жил бүр сумын төсөвт суулгахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх журмын дагуу жил бүр "Сумын аварга малчин", Сумын аварга саальчин"-ы шалгуурыг хангасан малчдын материалыг сумын Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэхүү журмыг сурталчилж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо, бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны "Журам батлах тухай" A/09 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА  Б.АЛТАНГЭРЭЛ